



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

“Монголын төмөр зам” төрийн өмчит
хувьцаат компанийн 2018 оны төлөвлөгөөнд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 627 дугаар тогтоолоор баталсан “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр хавсралтаар өөрчлөн баталсугай.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 627 дугаар тогтоолоор баталсан “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 2 дугаар хавсралтад заасан хөрөнгө оруулалтын ажлыг нэмсүгэй.

3.Компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт орсонтой холбогдуулан компанийн 2018 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авалтын төлөвлөгөөнд зохих өөрчлөлт оруулан баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

4.Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх захирал Б.Цэнгэлд даалгасугай.

5.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ


0001.07

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 04 дүгээр сарын 24 -ний өдрийн
14.6 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2018 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Х/н	2017 оны гүйцэтгэл	2018 оны		Харьцуулалт	
				Төлөвлөгөө	Төлөвлөгөө тодотголоор	2018 төл /2018 тод	2018 тод- 2018 төл
1	Нийт орлого	мян.төг	7,391,126.9	9,299,181.0	9,299,181.0	100.0	-
2	Нийт зардал	мян.төг	7,203,002.4	8,928,097.0	8,869,295.0	99.3	(58,802.0)
3	Үүнээс: Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	2,257,828.0	2,955,712.0	2,896,910.0	98.0	(58,802.0)
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	188,124.5	371,084.0	429,886.0	115.8	58,802.0
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	2,388,330.0	333,975.6	386,898.0	115.8	52,922.4
6	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	4,646,667.0	1,485,433.4	1,485,433.4	100.0	-
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	-	100,192.7	116,069.4	115.8	15,876.7
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	152	180	185	102.8	5
9	Нийт цалингийн сан	мян.төг	1,448,928.0	1,666,681.0	1,666,681.0	100.0	-
10	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	1,532.0	1,532.0	1,532.0	100.0	-
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.97	0.96	0.95	99.3	(0.0)
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	391,766.0	766,223.0	777,962.0	101.5	11,739.0
13	Нийт авлага	мян.төг	1,419,074.0	981,867.0	981,867.0	100.0	-
14	Нийт өглөг	мян.төг	95,958,693.0	94,040,174.0	94,040,174.0	100.0	-
15	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	9,329,181.0	5,345,157.0	5,345,157.0	100.0	-
16	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	86,629,512.0	88,695,017.0	88,695,017.0	100.0	-
17	Шинэ төмөр зам төсөлд санхүүжүүлэх дүн	мян.төг	2,463,195.0	3,897,377.0	3,842,283.0	98.6	(55,094.0)
18	"Ложиستيкийн төв" төсөлд санхүүжүүлэх дүн	мян.төг	-	-	93,954.0	-	93,954.0

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн
146 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД НЭМЭХ АЖИЛ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	2018 оны		Нийт үнэ (мян.төг)
				Төлөвлөгөө	Төлөвлөгөө тодотголоор	
1.Төв конторын үйл ажиллагаанд						
1	Конторын байр худалдан авах урьдчилгаа	ш	1	529,061.0	540,800.0	540,800.0
2018 оны хөрөнгө оруулалтын нийт дүн						777,962.0